

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг удирдах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хамгаалах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

2.1.Энэ хууль нь төрийн болон орон нутгийн өмч, гадаад улс болон нээлттэй далай тэнгис дэх Монгол Улсын төрийн өмчийн хөрөнгийн харилцаанд үйлчилнэ.

2.2.Үйл ажиллагааг нь тусгайлсан хуулиар зохицуулдаг, төрийн өмчид үндэслэн байгуулагдсан хуулийн этгээдийн хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах харилцааг энэ хуулиар зохицуулна.

2.3.Үйл ажиллагааг нь тусгайлсан хуулиар зохицуулдаг сангийн бүрдүүлэлт, хуваарилалт, захиран зарцуулалттай холбогдсон харилцаанд энэ хууль үйлчлэхгүй.

2.4.Төрийн нийтийн өмчийн талаар энэ хуульд зааснаас бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

2.5.Төрийн болон орон нутгийн өмчит хувийн эрх зүйн хуулийн этгээдийн энэ хуульд зааснаас бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

3 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж

3.1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

3.2.Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“төрийн байгууллага” гэж Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасны дагуу төрийн эрх мэдэл, чиг үүргийг хэрэгжүүлж, төсвөөс санхүүждэг байгууллага, тэдгээрийн харьяа салбар, нэгжийг;

4.1.2.“албан газар” гэж төрийн байгууллагад хамаарахгүй боловч хуульд заасны дагуу улс болон салбарын хэмжээнд нийгэм, эдийн засаг, шинжлэх ухааны тодорхой үйлчилгээ үзүүлэх, зохицуулах чиг үүрэгтэй төрийн эрх бүхий этгээдээс байгуулсан хуулийн этгээдийг;

4.1.3.“нийтийн байгууллага” гэж дэд бүтэц, соёл, урлаг, спорт, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээг нийтэд үзүүлэх чиг үүрэгтэй төрийн эрх бүхий этгээдээс байгуулсан хуулийн этгээдийг;

4.1.4.“өмчийн удирдлага” гэж өмчлөгч болон түүнээс эрх олгосон этгээдийн төрийн болон орон нутгийн өмчийн бүтэц, хөдөлгөөн, үр нөлөөтэй, үр ашигтай байдлын талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагааг;

4.1.5.“хөрөнгийн удирдлага” гэж тодорхой нэр төрлийн хөрөнгийн эзэмших ашиглах эрхийг хэрэгжүүлж, уг хөрөнгийг хууль, гэрээнд заасан нөхцөл, журамд нийцүүлэн зориулалтын дагуу үр ашигтай ашиглах, хэрэглэх, бусдад ашиглуулах, хэрэглүүлэх үйл ажиллагааг.

5 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн харилцаанд баримтлах зарчим

5.1.Төрийн болон орон нутгийн өмчийн харилцаанд дараахь зарчмыг баримтална:

5.1.1.ил тод, нээлттэй байх;

5.1.2.өмч, хөрөнгийн удирдлагыг үр нөлөөтэй, үр ашигтай хэрэгжүүлэх;

5.1.3.төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага нэгдмэл байх;

5.1.4.орон нутаг дахь өмчийн удирдлага хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд хэрэгжих.

5.2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, хөрөнгийг удирдах үйл ажиллагаанд олон хэвшил бүхий эдийн засаг, зах зээлийн өрсөлдөөн, жувийн өмчийн хөгжлийг дэмжих, судалгаа тооцоонд үндэслэсэн байх зарчмыг баримтална.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧ

6 дугаар зүйл.Төрийн өмчийн ангилал

6.1.Төрийн өмч нь төрийн нийтийн болон төрийн тусгайлсан өмчөөс бүрдэнэ.

7 дугаар зүйл.Төрийн нийтийн өмч

7.1.Үндсэн хууль, бусад хуулиар ард түмний мэдэлд байхаар заасан дараахь баялаг, түүнийг олж авах болон өмчлөх онцгой эрх, хөрөнгө төрийн нийтийн өмч мөн:

7.1.1.Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар;

7.1.2.газрын хэвлий, түүний баялаг;

7.1.3.ой, түүний нөөц, дагалдах баялаг;

7.1.4.ус, түүний нөөц, доторх баялаг;

7.1.5.ан амьтан.

7.2.Үндсэн хууль, бусад хуулиар төрийн хамгаалалтад байхаар заасан дараахь баялаг, хөрөнгө төрийн нийтийн өмчид хамаарна:

7.2.1.ургамал;

7.2.2.агаар;

7.2.3.агаарын орон зай;

7.2.4.түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон соёлын биет бус өв, их хаад, хатдын нэр.

7.3.Улсын Их Хурал нь ард түмнийг төлөөлөн төрийн нийтийн өмчид хамаарах баялаг, хөрөнгийн өмчлөгч байна.

7.4.Энэ хуулийн 7.1.2-7.1.5, 7.2.1-д заасан байгалийн баялаг, түүнийг олж авах болон өмчлөх онцгой эрхийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор энэ хуулийн 8.1-д заасан төрийн тусгайлсан өмчид эсхүл хувийн өмчид хуульд заасан үндэслэл журмын дагуу шилжүүлж болно.

7.5.Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хуулийн этгээдэд газрыг хуульд заасан болзол, журмын дагуу эд юмсын хязгаарлагдмал эрхтэйгээр төлбөр, хугацаатай зөвхөн ашиглуулж болно.

7.6.Агаарын орон зайг иргэн, хуулийн этгээдэд хууль, олон улсын гэрээнд заасан үндэслэл, журмын дагуу ашиглуулж болно.

7.7.Иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлж ашиглуулснаас бусад газар, ой, усанд иргэн чөлөөтэй нэвтрэх, хувийн болон гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар ашиглах, хэрэглэх, үр шимийг хүртэх эрхтэй.

8 дугаар зүйл.Төрийн тусгайлсан өмч

8.1.Төрийн тусгайлсан өмчид энэ хуулийн 7.1, 7.2-т зааснаас бусад дараахь хөрөнгө хамаарна:

8.1.1.түүх соёлын хөдлөх дурсгалт зүйл;

8.1.2.төрийн нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн хөрөнгө;

8.1.3.улсын төсвийн хөрөнгө;

8.1.4.Засгийн газрын сан;

8.1.5.төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн төрийн эзэмшлийн хувьцаа;

8.1.6.улсын нөөц;

8.1.7.төрийн хөрөнгөөр бүтээсэн, олж авсан оюуны өмч, эрх;

8.1.8.төрийн архивын сан хөмрөгийн баримт, хуульд заасан бүртгэл, мэдээлэл, мэдээллийн сан;

8.1.9.Эрдэнэсийн сан;

8.1.10.хуульд заасан бусад хөрөнгө.

8.2.Төрийн тусгайлсан өмчийн итгэмжлэгдсэн өмчлөгч нь Засгийн газар байна.

9 дүгээр зүйл.Орон нутгийн өмч

9.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор өмчтэй байна.

9.2.Орон нутгийн өмчид энэ хуулийн 7.1, 7.2, 8.1-д зааснаас бусад дараахь хөрөнгө хамаарна:

- 9.2.1.орон нутгийн өмчит нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн хөрөнгө;
- 9.2.2.орон нутгийн төсвийн хөрөнгө;
- 9.2.3.орон нутгийн сан, нөөц;
- 9.2.4.компанийн орон нутгийн өмчийн эзэмшлийн хувьцаа;
- 9.2.5.орон нутгийн хөрөнгөөр бүтээсэн, олж авсан оюуны өмч, эрх;
- 9.2.6.хуульд заасан бусад хөрөнгө.

9.3.Орон нутгийн өмчийн хөрөнгийн өмчлөгч нь тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байна.

9.4.Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд төрийн нийтийн өмчийн баялгийг хайх, олж авах, олборлох, худалдан борлуулах үйл ажиллагаа эрхлэх орон нутгийн өмчит компани байгуулах, хувьцаа эзэмшихийг хориглоно.

10 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хэлбэр

10.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө нь дараахь хэлбэртэй байна:

- 10.1.1.үл хөдлөх хөрөнгө;
- 10.1.2.хөдлөх хөрөнгө;
- 10.1.3.эдийн бус хөрөнгө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА

11 дүгээр зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

11.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн талаар Улсын Их Хурал дараахь бүрэн эрхтэй:

- 11.1.1.төрийн нийтийн өмчид хамаарах хөрөнгийг захиран зарцуулах, үр өгөөжийг ард түмэнд хүртээх;
- 11.1.2.төрийн нийтийн өмчид хөрөнгө олж авах;
- 11.1.3.өмчлөх эрхээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн Засгийн газар, түүний харьяа байгууллага эсхүл аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад шилжүүлэх, шилжүүлсэн эрхээ буцаан авах, шилжүүлсэн шийдвэрээ хүчингүй болгох;
- 11.1.4.төрийн нийтийн өмч, баялагт суурилсан компани, төрийн өмчит банк, стратегийн ач холбогдол бүхий үйл ажиллагаа эрхэлдэг компани, хөрөнгийг хувьчлах шийдвэр гаргах;
- 11.1.5.Улсын тусгай хэрэгцээ, нийтийн эрх ашгийг үндэслэн орон нутгийн өмчийн хөрөнгийг төрийн өмчид үл маргах журмаар шилжүүлэн авах;
- 11.1.6.хуульд заасан бусад бүрэн эрх.

12 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

12.1.Төрийн тусгайлсан өмчийн талаар Засгийн газар дараахь бүрэн эрхтэй:

- 12.1.1.төрийн өмчийн талаарх бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;
- 12.1.2.төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдал, уялдааг хангах;

12.1.3.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанид төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллагыг тогтоох;

12.1.4.төрийн тусгайлсан өмчид хөрөнгө олж авах;

12.1.5.хөрөнгийг захиран зарцуулах, эрхээ бусдад шилжүүлэх;

12.1.6.төрийн тусгайлсан өмчийн хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэх, шилжүүлсэн хөрөнгөө буцаан авах;

12.1.7.төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулах, өөрчлөн зохион байгуулах, дүрмийг батлах, хөрөнгө оруулах, оруулсан хөрөнгөө татан авах, татан буулгах шийдвэр гаргах;

12.1.8.төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн тооллогын дүнг хэлэлцэх, Улсын Их Хуралд танилцуулах;

12.1.9.энэ хуулийн 11.1.4-т зааснаас бусад төрийн өмчит хуулийн этгээд, хөрөнгийг хувьчлах шийдвэр гаргах;

12.1.10.төрийн эзэмшлийн хувьцаа, үл хөдлөх хөрөнгийг худалдах, шилжүүлэх шийдвэр гаргах;

12.1.11.хуульд заасан бусад бүрэн эрх.

12.2.Засгийн газар энэ хуульд заасан бүрэн эрхээ Төрийн өмчийн хороонд шилжүүлж болно.

13 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын эрх хэмжээ

13.1.Засгийн газрын гишүүн нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанид төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлнэ.

13.2.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанид төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийг тухайн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар томилж, чөлөөлнө. Төрийн өмчийн төлөөлөгчийн бүрэлдэхүүнд холбогдох төрийн захиргааны төв болон бусад байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

13.3.Төрийн өмчийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчийн, төрийн өмчийн төлөөлөгч нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

14 дүгээр зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

14.1.Орон нутгийн өмчийн талаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхтэй:

14.1.1.орон нутгийн өмчид хөрөнгө олж авах;

14.1.2.хөрөнгийг удирдах, захиран зарцуулах;

14.1.3.өмчлөх эрхээ бүхэлд нь эсхүл хэсэгчлэн шилжүүлэх, шилжүүлсэн эрхээ буцаан авах, шилжүүлсэн шийдвэрээ хүчингүй болгох;

14.1.4.орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгийг төрийн болон бусад өмчид шилжүүлэх, хувьчлах шийдвэр гаргах;

14.1.5.хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор орон нутаг дангаараа болон бусад өмчийн этгээдтэй хамтарч компани байгуулах, өөрчлөн зохион байгуулах, дүрмийг батлах, хөрөнгө оруулах, оруулсан хөрөнгөө татан авах, татан буулгах шийдвэр гаргах;

14.1.6.орон нутгийн өмчит компанийн төлөвлөлт, ашгийн хуваарилалт батлах;

14.1.7.орон нутгийн өмчийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, данснаас хасах, худалдах санал, захиалгыг хянаж шийдвэр гаргах;

14.1.8.орон нутгийн өмчийн тооллогын нэгдсэн дүнг хэлэлцэх;

14.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь орон нутгийн өмчийн хөрөнгийг хувьчлах шийдвэр гаргахын өмнө Төрийн өмчийн хороотой зөвшилцөнө.

14.3.Орон нутагт гадаад улс, гадаад улсын хуулийн этгээдтэй хамтарч хуулийн этгээд байгуулах, хувьцаа эзэмшихийг хориглоно.

15 дугаар зүйл.Төрийн өмчийн хороо

15.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн өмчийг мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргийг Төрийн өмчийн хороо хэрэгжүүлнэ.

15.2.Төрийн өмчийн хороо нь дарга, орон тооны бус найман гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээрийг Засгийн газар томилж, чөлөөлнө.

15.3.Төрийн өмчийн хороо нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд шийдвэр гаргах үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааны шийдвэр нь тогтоол, тэмдэглэл хэлбэртэй байна.

15.4.Хуралдааны дэг, гишүүдийн урамшууллын хэмжээг Төрийн өмчийн хороо тогтооно.

15.5.Төрийн өмчийн хороо нь орон нутагт нэгжтэй байна.

16 дугаар зүйл.Төрийн өмчийн хорооны эрх, үүрэг

16.1.Төрийн өмчийн хороо нь дараахь эрх, үүрэгтэй:

16.1.1.хуульд заасан чиг үүргийн хүрээнд Засгийн газрын бүрэн эрхэд хамаарах асуудлаар шийдвэрийн төслийг боловсруулах, танилцуулах;

16.1.2.энэ хуульд заасан дүрэм, журмыг батлах;

16.1.3.төрийн өмчит хуулийн этгээдийг хувьчлах, өөрчлөн байгуулах, татан буулгах, төрийн өмчийн хувьцааг худалдах шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах;

16.1.4.энэ хуульд зааснаар төрийн өмчит хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад төрийн өмчийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, данснаас хасах, худалдах санал, захиалгыг хянаж шийдвэр гаргах;

16.1.5.төрийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэх, зориулалтыг өөрчлөх, худалдахад зөвшөөрөл өгөх;

16.1.6.төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллого зохион байгуулах, бүртгэл, мэдээллийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, удирдах;

16.1.7.орон нутгийн Өмчийн газрыг мэргэжлийн нэгдсэн удирдлагаар хангах;

16.1.8.өмч, хөрөнгийн хяналтыг хэрэгжүүлэх;

16.1.9.хуульд заасан бусад.

16.2.Гүйцэтгэх ажлын зориулалттай эд хөрөнгийг худалдан авах, үйлдвэрлэх, эргэлтийн хөрөнгөд бүртгэх, захиран зарцуулах, шилжүүлэх, устгахтай холбогдох харилцааг Төрийн өмчийн хороо, тагнуулын төв байгууллагын даргатай хамтран баталсан журмаар зохицуулна.

17 дугаар зүйл.Засаг даргын эрх, үүрэг

17.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний хүрээнд орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

17.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь дараахь эрх, үүрэгтэй:

17.2.1.орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах;

17.2.2.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн өмчийн талаар гарсан шийдвэрийг Засгийн газрын бодлогод нийцүүлэн хэрэгжүүлэх, тайлагнах;

17.2.3.орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанид хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх;

17.2.4.орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөрөнгийн тооллогын ажлыг удирдах;

17.2.5.орон нутаг дахь төрийн өмчийг удирдах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

17.2.6.орон нутгийн өмч, хөрөнгийн хяналтыг хэрэгжүүлэх;

17.2.7.хуульд заасан бусад.

17.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь тухайн орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдал, уялдааг хангана.

17.4.Аймаг, нийслэлийн Засаг даргын тушаалаар орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанид төлөөлөгчийг томилж, чөлөөнө.

17.5.Орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчийн, төлөөлөгч нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

18 дугаар зүйл.Орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллага, түүний эрх, үүрэг

18.1.Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн агентлаг-Өмчийн газар /цаашид “Өмчийн газар” гэх/ байна.

18.2.Өмчийн газрын даргыг Төрийн өмчийн хорооны даргын зөвшөөрснөөр Засаг дарга томилно.

18.3.Өмчийн газар нь дараахь эрх, үүрэгтэй:

18.3.1.иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас орон нутгийн өмчийн талаар гарах шийдвэрийн төслийг боловсруулах, хэрэгжүүлэх;

18.3.2.орон нутгийн өмчид олж авсан хөрөнгийг бүртгэх, үнэлэх;

18.3.3.орон нутгийн өмчийн үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах, бүртгэл, мэдээллийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, удирдах;

18.3.4.орон нутгийн өмч, хөрөнгийн хяналтыг хэрэгжүүлэх.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД,
ТҮҮНИЙ ХӨРӨНГИЙН ЭРХ**

19 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ангилал

19.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг нийтийн эрх зүйн хуулийн этгээд, хувийн эрх зүйн хуулийн этгээд гэж ангилна.

19.2.Төрийн болон орон нутгийн өмчит нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг хөрөнгийн эрхийн байдлаар нь дор дурдсанаар ангилна:

19.2.1.төрийн байгууллага, албан газар;

19.2.2.нийтийн байгууллага.

19.3.Төрийн болон орон нутгийн өмчит хувийн эрх зүйн хуулийн этгээдийг хөрөнгийн эрхийн байдлаар нь дор дурдсанаар ангилна:

19.3.1.төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компани;

19.3.2.орон нутгийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани;

19.3.3.сан.

20 дугаар зүйл.Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн хөрөнгийн эрх

20.1.Нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь хөрөнгийн талаар дараахь нийтлэг эрх, үүрэгтэй:

20.1.1.өөрт олгогдсон хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах;

20.1.2.энэ хууль, дүрэмд нийцүүлэн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх;

20.1.3.төсвөөс олгосон хөрөнгийг холбогдох хуульд заасны дагуу зарцуулах, тайлагнах.

20.2.Албан газар, нийтийн байгууллага нь өөрийн үйл ажиллагааны орлогоо хууль, дүрэмд заасан чиг үүрэгтээ нийцүүлэн захиран зарцуулна.

20.3.Нийтийн байгууллага нь хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ, тарифыг өөрөө бие даан тогтооно.

20.4.Төрийн байгууллага аж ахуй, үйлчилгээний зориулалтаар хөрөнгийн удирдлагыг гэрээний үндсэн дээр бусад этгээдэд шилжүүлж болно.

20.5.Нийтийн байгууллага нь хөрөнгийн удирдлагыг гэрээний үндсэн дээр бусад этгээдэд хязгаарлагдмал эрхтэйгээр шилжүүлж болно.

20.6.Төсвийн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр тодорхой, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор төслийн нэгж, ашиглалтын өмнөх захиргааг хуулийн этгээдийн эрхгүйгээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар түр хугацаагаар байгуулж болно. Төслийн нэгж, ашиглалтын өмнөх захиргаа нь албан газрын нэгэн адил хөрөнгийн эрх эдэлнэ.

21 дүгээр зүйл.Хувийн эрх зүйн хуулийн этгээд, түүний хөрөнгийн эрх

21.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр дангаар эсхүл бусад этгээдтэй хамтарч хувь нийлүүлж байгуулсан, ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг Иргэний хуулийн 34 дүгээр зүйлд тодорхойлсон компанийн хэлбэрээр байгуулна.

21.2.Компани байгуулах, хувьцаа худалдан авахдаа дараахь шаардлагыг тавина:

21.2.1.шинээр байгуулах компани нь хувийн хэвшлийн этгээд хөрөнгө оруулах, гүйцэтгэх боломжтой ажил, үйлчилгээг эрхлэхгүй байх;

21.2.2.тухайн компанийн нийт энгийн хувьцааны хяналтын багцаас доошгүй хувь хэмжээг эзэмшиж байх;

21.2.3.компанийн энгийн хувьцааг бусад этгээдээс зээлээр авахгүй байх;

21.2.4.зээлийн санхүүжилт хийх, олох зорилго, нөхцөлтэйгээр төрийн өмчийн оролцоотой компани байгуулахгүй, хувьцаа эзэмшихгүй эсхүл бусад этгээдтэй хамтран ажиллахгүй байх;

21.2.5.Төрийн өмчийн хувь, оролцоог төлөөлөх этгээд компанийн удирдлагыг томилох, шийдвэр гаргах, хяналт тавих баталгаат нөхцлийг бизнесийн нийтлэг жишгээс дордуулахгүйгээр төрийн өмчийн компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн гэрээнд тусгах.

21.3.Төрийн өмчийн оролцоотой компанийн хуулиар тогтоосон удирдлагын бүтэцтэй давхцуулж компанийн үндсэн үйл ажиллагааны удирдлагыг өөр этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

21.4.Төрийн өмчит компанийн мэргэжлийн удирдлагыг тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

21.5.Төрийн болон орон нутгийн өмчит хувийн эрх зүйн хуулийн этгээд нь хөрөнгийн эрхээ өөрөө хэрэгжүүлнэ.

21.6.Төрийн болон орон нутгийн өмчит компанид төлөөлөгч томилох болон төлөөлөгчийн ажиллах журмыг Төрийн өмчийн хороо батална.

ТАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙГ ЭЗЭМШИХ, АШИГЛАХ, ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

22 дугаар зүйл.Төрийн өмчид хөрөнгө олж авах, бүртгэх

22.1.Төрийн өмчид хөрөнгийг дараахь үндэслэлээр олж авна:

22.1.1.төрийн өмчийн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулж, үр шим, ашиг олсны үр дүнд бий болсон хөрөнгө;

22.1.2.төрийн үйлчилгээ, үйл ажиллагааны орлогоор бий болсон хөрөнгө;

22.1.3.эрх бүхий байгууллагын баталсан төсөв, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу худалдан авсан болон хөрөнгө зарцуулсны үр дүнд шинээр бий болгосон хөрөнгө;

22.1.4.шүүхийн болон шүүхийн бус журмаар шаардах эрх, авлага, хохирлын нөхөн төлбөрт тооцон авсан, даатгалын нөхөн олговорт авсан хөрөнгө;

22.1.5. хандив, тусламж, бэлэглэл, өвлөх, эрх залгамжлах журмаар олж авсан хөрөнгө;
22.1.6. эзэнгүй болон дарагдмал эд хөрөнгө;
22.1.7. зээлээр авсан хөрөнгө;
22.1.8. сольж авсан хөрөнгө;
22.1.9. концессын гэрээний дагуу шинээр бий болсон эд хөрөнгө;
22.1.10. орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэн хөрөнгө;
22.1.11. эргүүлэн авсан, солиж авсан газар;
22.1.12. хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан үндэслэл, журмын дагуу шилжүүлэн авсан, дайчлан авсан, хураасан буюу улсын орлого болгосон хөрөнгө;
22.1.13. хуульд заасан бусад.

22.2. Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон эд хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.

22.3. Бусад этгээдтэй хамтарч хөрөнгө оруулсан бол төсвөөс санхүүжүүлсэн хувь хөрөнгийн хэмжээгээр төрийн болон орон нутгийн өмчид хамааруулна.

22.4. Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах Улсын комиссийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн хороо, Өмчийн газрын төлөөлөл заавал байна.

22.5. Татварын хууль тогтоомж ба бусад хуулийн дагуу улсын төсөв, тусгай санд төвлөрүүлсэн орлого, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийн дагуу төлүүлсэн торгууль, улсын орлого болгосон мөнгөн хөрөнгө нь төрийн өмчид хамаарах бөгөөд уг орлогыг бүртгэх, захиран зарцуулах асуудлыг Төсвийн тухай хуулиар зохицуулна.

22.6. Төрийн өмчийн хөрөнгийг олон улсын болон хөрөнгийн үнэлгээний үндэсний стандарт, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасны дагуу үнэлж, бүртгэнэ.

23 дугаар зүйл. Орон нутгийн өмчид хөрөнгө олж авах

23.1. Орон нутгийн өмчид хөрөнгийг энэ хуулийн 22.1.3-22.1.9-д зааснаас гадна дараахь үндэслэлээр олж авна:

- 23.1.1. төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлсэн хөрөнгө;
- 23.1.2. орон нутгийн өмчийн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулж, үр шим, ашиг олсны үр дүнд бий болсон хөрөнгө;
- 23.1.3. орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйлчилгээ, үйл ажиллагааны орлогоор бий болсон хөрөнгө;
- 23.1.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн өмчид зориулж бэлтгэсэн хөрөнгө.

24 дүгээр зүйл. Хандив, тусламж, бэлэглэл, өв, эрх залгамжлалын журмаар хөрөнгө олж авах

24.1. Монгол Улс, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд бэлэглэсэн, хандивласан, буцалтгүй тусламжаар олгосон авсан хөрөнгийн чанар

байдалд хяналт тавьж, үнийг тогтоож төрийн өмчид бүртгэх, удирдах этгээдийг тогтоох асуудлыг Төрийн өмчийн хороо шийдвэрлэнэ.

24.2.Хандив, тусламж, бэлэглэл, өвийн журмаар авсан хөрөнгө нь орон нутагт зориулсан бол уг хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэж, шилжүүлж болно.

24.3.Хэрэгцээ шаардлагагүй, илүү зардал гарах, үүрэг хүлээх эрсдэлтэй хөрөнгийг бэлэг, хандив, өвийн журмаар хүлээн авахаас татгалзах эрхтэй.

25 дугаар зүйл.Хураан авах журмаар хөрөнгө олж авах

25.1.Шүүхийн болон захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэрийн дагуу хураан авч төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлсэн хөрөнгийн тухай мэдээллийг тухайн хөрөнгийг хураан авсан байгууллага, албан тушаалтан Төрийн өмчийн хороо, Өмчийн газарт хүргүүлнэ.

25.2.Хураан авсан мөнгөн болон түргэн хөрвөх чадвартай хөрөнгийг улсын орлого болгож төсвийн дансанд оруулна.

25.3.Хураан авсан эд зүйлийг хураан авсан байгууллага, албан тушаалтан өөрийн эзэмшил, хяналт дор хадгалж, зохих журмын дагуу дуудлага худалдаа эсхүл ердийн журмаар худалдан борлуулах үүрэг хүлээнэ.

25.4.Төрийн өмчийн хороо нь хэрэгцээ, шаардлага хангахгүй, түргэн муудаж гэмтэх, орчиндоо аюултай, хадгалалтын өндөр зардалтай эд зүйлийг төрийн өмчид хүлээн авахаас татгалзах эрхтэй. Энэ тохиолдолд хураан авсан байгууллага, албан тушаалтныг оролцуулсан комисс байгуулж хөрөнгийг эзэнд нь буцаан өгөх эсхүл устгах арга хэмжээг авна.

26 дугаар зүйл.Хөрөнгийг эзэмших, ашиглахад тавих шаардлага

26.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд өөрт олгогдсон хөрөнгийг эзэмшиж, ашиглахад дараахь шаардлагыг тавина:

26.1.1.хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгийн бүртгэл, хувийн хэрэг хөтлөх, улсын бүртгэлд бүртгүүлэх, хөрөнгөнд танигдах тэмдэг, тэмдэглэгээ хийх, хөрөнгийн тооллого хийх, санхүүгийн болон статистикийн мэдээ, тайлан гаргах;

26.1.2.хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, арчлах, зохистой болон аюулгүйн нөөц бүрдүүлэх, эрсдэлээс хамгаалах, даатгуулах;

26.1.3.илүүдэл, ашиглалтгүй хөрөнгийг түрээслэх, хөлслөх, худалдах, актлах, үр ашгийг дээшлүүлэх арга хэрэгслийг ашиглах;

26.1.4.өмчлөгч, эзэмшигчийн эрхээ баталгаажуулах, эрхээ зөрчигдөхөөс хууль зүйн арга, хэрэгслийг ашиглан хамгаалах;

26.1.5.эд хариуцагчтай хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулах;

26.1.6.дотоод хяналт, хяналт-шинжилгээ, үнэлгээг зохион байгуулах;

26.1.7.хөрөнгийн үйлчилгээ, ашиглалтын найдвартай, аюулгүй байдлыг хангаж бусдад гэм хор учруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авах.

27 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах

27.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг энэ хуулиар тогтоосон журмын дагуу бусад этгээдэд эзэмшүүлэх, хөлслүүлэх, түрээслүүлэх, узуфрукт, сервитутээр ашиглуулж болно.

27.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах журам, гэрээний үлгэрчилсэн загвар, төлбөрийн жишиг доод хэмжээ, түрээслэгчийг сонгон шалгаруулах, түрээсийн зүйлд хөрөнгө оруулах журмыг Төрийн өмчийн хороо баталж, төлбөрийн доод хэмжээг тогтооно.

27.3.Түрээсэлсэн эд хөрөнгийг худалдах тохиолдолд түрээслэгчид Иргэний хуулийн 105 дугаар зүйлд заасан эрх эдлүүлэх эсэхийг Төрийн өмчийн хороо шийдвэрлэнэ.

27.4.Төрийн өмчийн хороо хөрөнгө ашиглуулах гэрээний нэгдсэн бүртгэлийг хөтөлж, хяналт тавьж ажиллана.

27.5.Хууль тогтоомжид заасан тохиолдолд төрийн тодорхой чиг үүргийг хууль болон гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод төрийн өмчийн хөрөнгийг үнэ төлбөргүй эсхүл хөнгөлөлтэй нөхцлөөр ашиглуулж болно.

27.6.Олон улсын төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах зорилгоор төрийн өмчийн хөдлөх эд хөрөнгийг түүний ашиглалтад төлбөртэй болон төлбөргүй ашиглуулж болно.

27.7.Төрийн өмчийн хороо хөрөнгө ашиглуулах үйл ажиллагаанд хяналт тавих бөгөөд илүүдэл, ашиглалтгүй хөрөнгийг төрийн өмчит нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс буцааж шилжүүлэн авах арга хэмжээ авна.

27.8.Иргэний хуульд заасан гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах аргын талаар гэрээнд тусгана.

28 дугаар зүйл.Төрийн өмчийн хөрөнгийг төрийн өмчит хуулийн этгээдэд ашиглуулах

28.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг төрийн байгууллага, албан газарт албан ажлын хэрэгцээнд зориулан үнэ төлбөргүй ашиглуулж болох бөгөөд ашиглалтын зардлыг төлнө.

28.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг нийтийн байгууллагад төлбөртэй ашиглуулахдаа тухайн этгээдийн үйл ажиллагааны зорилго, чиглэл, нийтийн эрх ашгийг харгалзан зохих хөнгөлөлт үзүүлж болно.

28.3.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг бусдад ашиглуулахаас өмнө тухайн хөрөнгө төрийн болон орон нутгийн бусад байгууллагад хэрэгцээтэй эсэхийг тогтоох, магадлах ажиллагааг явуулна.

29 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчид эд юмсын хязгаарлагдмал эрх үүсгэх

29.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг эд юмсын хязгаарлагдмал эрхээр ашиглуулах бол гэрээнд хязгаарлагдмал эрхийн төрөл, агуулгыг тусгана.

29.2.Төрийн өмчийн газрыг барилга байгууламж барих хязгаарлагдмал эрхээр ашиглуулах тухай шийдвэрт эд юмсын хязгаарлагдмал эрхийн гэрээний нөхцөлийн талаарх мэдээллийг тусгана.

29.3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг узурфруктээр ашиглуулах бол уг эрхийг олж авч байгаа этгэ эдийн тухай дараахь мэдээллийг тусгана:

29.3.1.хувь хүн бол овог нэр, регистрийн дугаар, төрсөн он, сар, өдөр, оршин суугаа газрын хаяг;

29.3.2.хуулийн этгээд бол нэр, регистрийн дугаар,оршин байх хаяг.

29.4.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг сервитутээр ашиглуулах тухай шийдвэрт сервитут хэрэгжих талбай, нэвтрэх буюу зорчих хэсгийн зураглалыг хавсаргана.

30 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчид үүсгэсэн эд юмсийн хязгаарлагдмал эрхийн гэрээ

30.1.Төрийн болон орон нутгийн өмчид эд юмсын хязгаарлагдмал эрх үүсгэх тухай гэрээ нь хууль, хязгаарлагдмал эрх үүсгэх тухай шийдвэрт нийцсэн байна.

30.2.Хязгаарлагдмал эрх бүхий этгээд нь уг эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэх, сервитут тогтоох, уг эрхийн үндсэн дээр баригдсан байгууламжийг гуравдагч этгээдэд ашиглуулахдаа хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгчээс зөвшөөрөл авна.

30.3.Төрийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулсан газар дээр барилга байгууламж барих эрхийг харилцан тохиролцсон зорилгоос өөрөөр ашигласан бол төрийн, эсхүл орон нутгийн өмчийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгоно.

30.4.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил, ашиглалтад олгосон газар дээр иргэн, бусад өмчийн хуулийн этгээдийн барилга барихыг хориглоно.

31 дүгээр зүйл.Эд юмсын хязгаарлагдмал эрхийн төлбөр

31.1.Төрийн болон орон нутгийн өмчид үүсгэсэн эд юмсын хязгаарлагдмал эрхийн төлбөрийг эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч гэрээний үндсэн дээр тохирно.

31.2.Хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь нөхцөл байдал өөрчлөгдсөн эсхүл эд юмсын хязгаарлагдмал эрх үүссэнээс хойш 3 жил тутамд уг эрхийн төлбөрийн хэмжээнд тохируулга хийхийг шаардах эрхтэй.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, ДАНСНААС ХАСАХ

32 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг шилжүүлэх үндэслэл

32.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг дараахь тохиолдолд хариу төлбөртэй эсхүл хариу төлбөргүй бусдад шилжүүлж болно:

32.1.1.илүүдэлтэй, ашиглах хугацаа нь дууссан, осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь үр ашиггүй болсон;

32.1.2.энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон;

32.1.3.хуульд заасны дагуу хувийн эрх зүйн хуулийн этгээдийн хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийх буюу төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх замаар төлөх болсон, хувь нийлүүлсэн;

32.1.4.эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр бусдад хандивлах, тэтгэмж, тусламж, дэмжлэг үзүүлэх болсон;

32.1.5.өр, бусдад учирсан хохирлыг нөхөн төлсөн;

32.1.6.эрх бүхий байгууллагын хөрөнгө худалдах, шийдвэр гарч хэрэгжсэн;

32.1.7.солилцоо хийсэн хөрөнгийн төлбөрт тооцож өгсөн;

32.1.8.хуульд заасан бусад.

32.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад шилжүүлэхийн өмнө тухайн хөрөнгө нь төрийн, эсхүл орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагагүй болсон эсэх талаар дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд тусгайлсан үнэлгээ хийлгэх, үл хөдлөх хөрөнгийн хувьд магадлах ажиллагаа явуулна.

32.3.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг түүний бодит үнэлгээнээс багагүй хэмжээний төлбөртэйгөөр бусдад шилжүүлнэ.

32.4.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийг энэ хуульд заасан үндэслэл, журмаар аливаа этгээд шилжүүлж болно.

32.5.Энэ хуульд заасан төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх, данснаас хасах журам, аргачлал, гэрээний загварыг Төрийн өмчийн хороо батална.

33 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг шилжүүлэх арга

33.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийг дараахь аргаар бусдын өмчлөлд шилжүүлнэ:

33.1.1.нээлттэй эсхүл хаалттай дуудлага худалдаа;

33.1.2.шууд эзэмшилд шилжүүлэх.

33.2.Төрийн болон орон нутгийн өмчийн үнэт цаас, шаардах эрх, урлагийн бүтээл зэрэг үнэлгээг нь шууд тогтоох боломжгүй хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх тусгай аргыг ашиглаж болно.

33.3.Төрийн өмчит хуулийн этгээдийн хооронд хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлж болно. Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, хөдлөх хөрөнгийг Төрийн өмчийн хорооны шийдвэрээр, зөвшөөрөл олгосон тохиолдолд эрх бүхий этгээдийн шийдвэрээр шилжүүлнэ.

33.4.Компанийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг компанийн эрх бүхий этгээдийн шийдвэрээр шилжүүлнэ.

33.5.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусдын өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно.

33.6.Төрийн өмчийн эд хөрөнгөөс нэг удаагийн тэтгэмж, тусламж олгох журмыг Засгийн газар батална.

34 дүгээр зүйл.Хөрөнгийг хариу төлбөргүй, эсхүл ердийн үнэлгээнээс бага үнээр шилжүүлэх

34.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үнэт цааснаас бусад хөрөнгийг дараахь тохиолдолд хариу төлбөргүй, эсхүл ердийн үнээс доогуур үнээр бусдын өмчлөл, ашиглалтад шилжүүлж болно:

34.1.1.нутгийн удирдлагын байгууллага хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчийн хөрөнгийг шилжүүлэн авах хүсэлт гаргасан;

34.1.2.төрийн өмчит хуулийн этгээд үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг шилжүүлэн авах хүсэлт гаргасан;

34.1.3.хуульд заасан бусад.

34.2.Энэ хуулийн 33.1-д заасан үндэслэлээр төрийн өмчийн хөрөнгийг хариу төлбөргүй буюу ердийн үнэлгээнээс доогуур үнээр шилжүүлэн авсан этгээд хөрөнгийг шилжүүлэн авсан зорилгын дагуу ашиглаагүй тохиолдолд төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах, хөрөнгийг буцаан авах, хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй.

35 дугаар зүйл.Хөрөнгийг өөр хөрөнгөөр солих

35.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хэрэгцээгүй боловч бусад этгээдэд хэрэгцээтэй хөрөнгийг өөрт хэрэгцээтэй хөрөнгөөр гэрээ байгуулах замаар сольж болно.

35.2.Хөрөнгийн солилцоо хийх нөхцөл, шаардлагыг ил тод зарлаж, солилцоо хийх этгээдийг нээлттэй сонгон шалгаруулна.

35.3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн солилцоог нийтийн эрх ашигт нийцсэн, үр ашигтай нөхцөлд хийнэ.

35.4.Хөрөнгийн солилцоо хийхийн өмнө төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч этгээдийн захиалгаар хөндлөнгийн хараат бус үнэлгээчнээр харилцан солилцох хөрөнгө тус бүрийн зах зээлийн үнэлгээг хийлгэнэ.

35.5.Сольж буй хөрөнгийн зах зээлийн үнийн зөрүү үл хөдлөх эд хөрөнгийн хувьд 10 хувиас, хөдлөх эд хөрөнгийн хувьд 30 хувиас хэтрэхгүй байна.

35.6.Солилцож буй хөрөнгийн үнийн зөрүүнд хүлээн авсан орлогыг тухайн компанид болон улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

35.7.Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг Засгийн газрын зөвшөөрлөөр солино.

35.8.Соёлын биет өв буюу түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийг солилцохыг хориглоно.

36 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг шилжүүлэх бэлтгэл хангах, шийдвэр гаргах

36.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хөрөнгийн өмчлөгч эсхүл тухайн хөрөнгийг бусдад шилжүүлэх эрх бүхий этгээд хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх тухай шийдвэр гаргана.

36.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг шилжүүлэх тухай шийдвэр дараахь агуулгатай байна:

36.2.1.шилжүүлэхээр төлөвлөж байгаа хөрөнгийн дүрслэл, тодорхойлолт;

36.2.2.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад шилжүүлэх болсон хуулийн үндэслэл, шалтгаан, үнэлгээний тайлан, дүгнэлт;

36.2.3.хөрөнгийг хүлээлгэн өгөх, өмчлөх эрхийг шилжүүлэх журам;

36.2.4.шилжүүлэн өгөх этгээдийг сонгон шалгаруулах арга, тухайн аргыг тогтоосон үндэслэл;

36.2.5.худалдах, солих доод үнэ, үнэ тогтоосон аргачлал, төлбөрийн нөхцөл;

36.2.6.уралдаант шалгаруулалтаар худалдах бол худалдах бусад нэмэлт нөхцөл;

36.2.7.сольж шилжүүлэхээр бол солих нэмэлт нөхцөл;

36.2.8.хөрөнгө шилжүүлэх ажлыг зохион байгуулах, төлөөлөн гэрээ байгуулах этгээд, түүний эрх, үүрэг;

36.2.9.хөрөнгө шилжүүлэх ажлыг зохион байгуулах зардал, зардлын эх үүсвэр.

36.3.Төрийн болон орон нутгийн өмчийн үнэт цаасыг шилжүүлэх шийдвэрт тусгагдах нэмэлт нөхцөлийг холбогдох хуулиар нарийвчлан зохицуулна.

37 дугаар зүйл.Хөрөнгийг шилжүүлэх ажиллагаа

37.1.Эрх бүхий этгээд эсхүл түүний томилсон, эрх олгосон этгээд холбогдох гэрээг байгуулах, гэрээний гүйцэтгэлийг хангах, хөрөнгийг хүлээлгэн өгөх, өмчлөх эрх шилжүүлэх, төлбөр эсхүл солих хөрөнгийг хүлээн авах, баримт бичгийн бүрдлийг хангах ажиллагааг хариуцан гүйцэтгэнэ.

37.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад шилжүүлэх ажлыг зохион байгуулсан этгээдийн ажлын тайлан дүгнэлтийг үндэслэн эрх бүхий этгээд тухайн хөрөнгийг шилжүүлсэн тухай шийдвэр гаргана.

38 дугаар зүйл.Эд хөрөнгийг ашиглах боломжгүй болсонд тооцож, данс бүртгэлээс хасах

38.1.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг дараахь тохиолдолд ашиглах боломжгүй болсонд тооцно:

38.1.1.ашиглалт, эдэлгээний хугацаа дууссан ба цаашид ашиглах, хэрэглэх эдийн засгийн үр ашиггүй эсхүл ашиглалт, хадгалалтын өндөр зардал гарах болсон;

38.1.2.иргэний гүйлгээнд оруулахыг хуулиар хориглосон;

38.1.3.Улс, олон нийтийн болон хувь хүний аюулгүй байдалд илт ноцтой сөрөг нөлөө үзүүлэх шинжтэй болсон;

38.1.4.ашиглалт, эдэлгээний хугацаа дуусаагүй боловч цаашид ашиглах, хэрэглэх эдийн засгийн үр ашиггүй болох нь тогтоогдсон, эсхүл ашиглалт, хадгалалтын өндөр зардал гарах болсон;

38.1.5.ашиглалт, эдэлгээний хугацаа дуусаагүй боловч төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын хэрэгцээ, шаардлагыг хангахгүй болсон;

38.1.6.бүрэн болон хэсэгчлэн утсан, гэмтсэн, тоногдсон, муудсан, хулгайлагдсан, алдагдсан зэрэг шалтгааны улмаас ашиглах, хэрэглэх, шилжүүлэх боломжгүй болсон.

38.2.Төрийн болон орон нутгийн өмчийн нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг ашиглах боломжгүй болсонд тооцож, данс бүртгэлээс хасах шийдвэрийг хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч этгээдийн саналыг, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тус тус үндэслэн Төрийн өмчийн хороо гаргана.

38.3.Төрийн болон орон нутгийн өмчийн нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан 38.1.1-38.1.4.-д заасан үндэслэлээр 38.2-т зааснаас бусад хөрөнгийг ашиглах боломжгүйд тооцож данс, бүртгэлээс хасах шийдвэрийг гаргана.

38.4.Энэ хуулийн 38.1.4-38.1.5.-д заасан үндэслэлээр хөдлөх эд хөрөнгийг ашиглах боломжгүйд тооцох шийдвэрийг тухайн эд хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж буй төрийн өмчит этгээдийн удирдлага өмч хамгаалах зөвлөл ба тооллогын комиссын саналыг үндэслэн гаргана.

38.5.Энэ хуульд тохиолдолд хөдлөх эд хөрөнгийг ашиглах боломжгүйд тооцох шийдвэрийг тухайн эд хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж буй төрийн өмчит этгээдийн удирдлага өмч хамгаалах зөвлөл ба тооллогын комиссын саналыг үндэслэн гаргана.

38.6.Энэ хуулийн 38.1.6-д заасан үндэслэлээр хөрөнгө данснаас хасах тохиолдолд буруутай этгээдийг тогтоож, хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

38.7.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглах боломжгүй болсонд тооцох шийдвэрт тухайн хөрөнгийн зураглал, тодорхойлолт, төлөв байдлыг дурдаж, шийдвэр гаргасан шалтгаан, үндэслэл болон бусдад шилжүүлэх, устгах, нурааж буулгах, хаях арга замыг тодорхой тусгана.

38.8.Төрийн өмчийн компанийн эрх бүхий этгээд энэ хууль болон дүрэмд заасан үндэслэлээр, Өмч хамгаалах байнгын зөвлөл ба тооллогын комиссын санал, дүгнэлтэд тулгуурлан өөрийн эзэмшлийн хөрөнгийг ашиглах боломжгүйд тооцож, данс бүртгэлээс хасах шийдвэрийг гаргана.

38.9.Газар эзэмших эрхийг Төрийн өмчийн хороо, Өмчийн газрын зөвшөөрөлгүйгээр данс, бүртгэлээс хасахыг хориглоно.

39 дүгээр зүйл.Хөрөнгийг данс бүртгэлээс хасах, устгах, хаях

39.1.Ашиглах боломжгүй болсонд тооцогдсон хөрөнгийг бусдад шилжүүлсэн, устгасан, барилга байгууламж бол нурааж буулгасан, хаясан, сэлбэгээр ашиглах болсон тухай тэмдэглэгээг холбогдох бүртгэл, хувийн хэрэгт хийж, данс бүртгэлээс хасна.

39.2.Ашиглах боломжгүй болсонд тооцогдсон эд хөрөнгийг устгах, нурааж буулгах, хаях тохиолдолд түүнийг хамгийн бага зардлаар, байгаль орчинд ээлтэй хэлбэрээр гүйцэтгэнэ.

39.3.Ашиглах боломжгүй болсонд тооцогдсон эд хөрөнгийг устгах, нурааж буулгах, хаях, данснаас хасах, уг хөрөнгийг өмчлөх эрх дуусгавар болох нөхцөл, журмыг хуульд нийцүүлэн Төрийн өмчийн хороо батална.

39.4.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг буулгаж, данснаас хассан нь түүний доорх төрийн өмчийн газар эзэмших эрхийг дуусгавар болгох үндэслэл болохгүй.

40 дүгээр зүйл.Үл хөдлөх эд хөрөнгө шаардлагатай эсэхийг магадлах ажиллагаа

40.1.Үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх, бусдад ашиглуулахаас өмнө төрийн бусад хэрэгцээнд шаардлагатай эсэхийг тодорхойлохоор магадлах ажиллагаа хийнэ. Магадлах ажиллагаанд дор дурдсан этгээдүүд оролцоно:

40.1.1.төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч бусад этгээд;

40.1.2.хот төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага;

40.1.3.үл хөдлөх эд хөрөнгө байрлаж байгаа нутаг дэвсгэрийг харьялах орон нутгийн захиргааны байгууллага;

40.1.4.төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн талаар нэгдсэн үйлчилгээ үзүүлэх зорилготой байгууллага;

40.1.5.энэ хуульд заасан чиг үүргээ биелүүлэх зорилготой нийтийн эрх зүйн хуулийн этгээд;

40.1.6.үүсгэн байгуулах баримт бичиг, дүрэмд заасаг чиг үүргээ биелүүлэх зорилгоор төрийн үүсгэн байгуулсан ашгийн бус холбоо, сан.

40.2.Дараахь тохиолдолд магадлах ажиллагаа хийхгүй байж болно:

40.2.1.энэ хуульд заасны дагуу үл хөдлөх хөрөнгийг ашиглуулж байгаа;

40.2.2.үл хөдлөх эд хөрөнгийг нийтийн хэрэгцээний шугам сүлжээний ажил, улсын болон орон нутгийн чанартай автозамын ажилд ашиглуулж байгаа;

40.2.3.үл хөдлөх эд хөрөнгөд сервитутын эрх үүсгэж байгаа.

40.3.Үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах төрийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоход энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан бүртгэлийг ашиглана.

40.4.Төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчид үл хөдлөх эд хөрөнгө шаардлагагүй бол үл хөдлөх эд хөрөнгийн хэрэгцээг тодорхойлох магадлах ажиллагаа явуулах тухай мэдэгдэл гаргаж нийтэд мэдээлнэ. Магадлах ажиллагааг

эхлүүлэхээс өмнө ирүүлсэн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах тухай хүсэлтийг мэдэгдэлд хавсаргана.

40.5.Төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, эсхүл түүнээс удирдлагын эрхийг шилжүүлэн авсан эрх бүхий этгээд нь мэдэгдлийг нийтлүүлсэн өдрөөс хойш 21 өдрийн дотор үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах хэрэгцээ шаардлагатай болохоо илэрхийлж, үндэслэлээ дурдан хүсэлт гаргана. Эрх бүхий этгээд дурдсан хугацаанд хүсэлтээ гаргаагүй бол түүнд тус үл хөдлөх эд хөрөнгө шаардлагагүй бөгөөд хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэхэд татгалзах зүйлгүй гэж үзнэ.

40.6.Төрийн өмчийн удирдлага хэрэгжүүлэгчээс ирүүлсэн хүсэлт нь эрх бүхий бусад этгээдээс ирүүлсэн хүсэлтээс давуу эрхтэйд тооцогдоно.

40.7.Энэ хуулийн 40.1-40.5-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлсний дараа магадлах ажиллагааг эхлүүлнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ ДУУДЛАГА ХУДАЛДАА, УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ

41 дүгээр зүйл. Дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалт

41.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад ашиглуулах, бусдын удирдлага, өмчлөлд шилжүүлэхдээ дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.

41.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад ашиглуулах, бусдын удирдлага, өмчлөлд шилжүүлэх нээлттэй дуудлага худалдаа болон уралдаант шалгаруулалт явуулах тухай мэдээллийг оролцогчдын саналаа ирүүлэх хугацаанаас 14-өөс доошгүй хоногийн өмнө нийтэд зарлаж мэдэгдэнэ.

41.3.Энэ хуулийн 39.2-д заасан мэдэгдэлд шилжүүлэх, ашиглуулах хөрөнгө, гэрээний төслийн талаарх мэдээлэл, дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалтын явуулах хугацаа, хураамж, дэнчин ба бусад нөхцөлийг тусгасан байна.

41.4.Дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалтын талаар мэдэгдэх, сурталчлах ажлыг энэ хуулийн 39.3-д зааснаас гадна бусад нэмэлт арга хэрэгслээр нийтэд түгээж болно.

41.5.Дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалтын тухай нийтэд мэдээлснээс хойш сонирхогч аливаа этгээд зохион байгуулагчийн тогтоосон газар, цагт ашиглуулах, шилжүүлэх хөрөнгийг үзэж, шалгаж болох ба холбогдох гэрээний нөхцөл, саналын дуудлагатай танилцаж болно.

41.6.Төрийн өмчийн компанийн үнэт цаас, хувьцааг уралдаант шалгаруулалт, дуудлага худалдаагаар шилжүүлэхтэй холбоотой харилцааг тусгай хуулиар зохицуулна.

41.7.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад ашиглуулах, бусдын удирдлага, өмчлөлд шилжүүлэх нээлттэй ба хаалттай дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалт зохион байгуулах нарийвчилсан журам, баримт бичгийн загварыг энэ хуульд нийцүүлэн Төрийн өмчийн хороо батална.

42 дугаар зүйл. Дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалтад оролцох хураамж ба дэнчин

42.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах, шилжүүлэх шийдвэр гаргасан эсхүл зохион байгуулах этгээд уралдаант шалгаруулалт, дуудлага худалдаанд оролцох хураамж болон гэрээ байгуулах дэнчингийн хэмжээг тус тус тогтооно.

42.2. Уралдаант шалгаруулалт, дуудлага худалдаанд оролцох хураамжийг тухайн хөрөнгийн бодит үнийн 2 хувь хүртэл хэмжээгээр тогтоож болно. Энэхүү хураамжийн хэмжээг тогтоохдоо дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах зардал, хүлээгдэж байгаа оролцогчдын тоо зэргийг үндэслэнэ.

42.3. Уралдаант шалгаруулалт, дуудлага худалдаанд оролцогчийн гэрээ байгуулах үүргийн гүйцэтгэлийн дэнчинд төлөх мөнгөний дүнг тухайн хөрөнгийн бодит үнийн 10 хувь хүртэл хэмжээгээр тогтоож болно.

42.4. Уралдаант шалгаруулалт, дуудлага худалдаанд оролцогч ялагч болсон боловч зохих хугацаанд гэрээ байгуулаагүй, байгуулахаас татгалзсан, эсхүл гэрээний үүргийг гүйцэтгэх баталгаа гаргаж чадаагүй нөхцөлд дэнчингийн мөнгийг уралдаант шалгаруулалт, дуудлага худалдаа зохион байгуулагчийн мэдэлд үлдээж гарсан болон ирээдүйд гарах зардал, хохирлыг арилгахад зарцуулна.

43 дугаар зүйл. Дуудлага худалдааны аргыг хэрэглэх

43.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн цаашдын зориулалтын талаар тусгайлсан болзол тавих шаардлагагүй тохиолдолд дуудлагын худалдааны аргыг хэрэглэнэ.

43.2. Дуудлага худалдаанд оролцогчийн санал дуудлага худалдааны дүн гартал хүчинтэй гэж тооцогдох ба дуудлага худалдаанд ялагчийн үнийн саналыг гэрээ байгуулах хүртэл хүчинтэй гэж үзнэ.

43.3. Дуудлага худалдааг биечлэн, бичгээр, эсхүл цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

43.4. Дуудлага худалдааны нөхцөлийн дагуу хураамж, дэнчинг төлсөн оролцогчдыг урьдчилан бүртгэж, зохион байгуулагчийн тогтоосон цаг, газарт ирж биечлэн оролцох боломжтой дуудлага худалдааг зохион байгуулж болно.

43.5. Бичгээр зохион байгуулсан дуудлага худалдаанд оролцогчид дуудлага худалдааны нөхцөлийн дагуу тогтоосон өдөр битүүмжилсэн дугтуйнд хийсэн саналаа ирүүлнэ.

43.6. Цахим хэлбэрээр дуудлага худалдаа явуулах бол оролцогчид нийтийн харилцаа холбооны сүлжээгээр дамжуулан хэрэглэгчийн нэрээр дуудлага худалдаа зохион байгуулагчтай холбогдож, дуудлага худалдааны саналаа гаргана. Дуудлага худалдаанд оролцогчийн үнийн санал бусад бүх оролцогчдод нэгэн зэрэг ил харагдах боломжтой байна.

43.7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн цахим дуудлага худалдааны журмыг Төрийн өмчийн хороо батална.

44 дүгээр зүйл. Дуудлага худалдааны доод үнэ

44.1. Эд хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар ашиглуулах, шилжүүлэхээр шийдвэрлэсэн этгээд эд хөрөнгийн санал болгох доод үнийг тогтооно.

44.2. Эд хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдаагаар шийдвэрлэсэн этгээдийн захиалгаар дотоодын үнэлгээчин болон хөндлөнгийн хараат бус үнэлгээчин эд хөрөнгийн санал болгох үнийг тогтооно.

44.3. Хоёр дахь дуудлага худалдааны доод үнийг анхны дуудлага худалдааны доод үнийг 20 хүртэл хувиар багасган тогтооно.

44.4. Уралдаант шалгаруулалт, гурав дахь дуудлага худалдаа, нэмэлт дуудлага худалдаанд доод үнийг тогтоох шаардлагагүй.

45 дугаар зүйл. Дуудлага худалдааны үр дүнгийн талаар мэдэгдэх

45.1. Биечилсэн дуудлага худалдааны ялагч ба хоёр дахь дээд үнийн санал гаргагчийн үнийн санал, бүртгэлийн дугаарыг дуудлага худалдааны ялагч тодормогц зарлан мэдэгдэнэ.

45.2. Бичгээр зохион байгуулсан дуудлага худалдааны зохион байгуулагч нь дуудлага худалдааны үр дүн, ялагч болон хоёр дахь дээд үнийн санал гаргагчийн нэрийг дуудлага худалдаа явуулснаас хойш ажлын 5 өдрийн дотор дуудлага худалдааны бүх оролцогчид бичгээр мэдэгдэнэ.

45.3. Цахим дуудлага худалдааны үр дүнг ялагч тодормогц бүх оролцогчид нийтийн харилцаа холбооны сүлжээгээр дамжуулан тэр даруй мэдэгдэнэ.

46 дугаар зүйл. Дуудлага худалдааны үр дүнг батлах

46.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар ашиглуулах, шилжүүлэх тухай шийдвэр гаргасан этгээд дуудлага худалдааны үр дүнг хүлээж авснаас хойш 20 хоногийн дотор дуудлага худалдааг хүчинтэй эсэхийг баталгаажуулна.

46.2. Дор дурдсан тохиолдолд энэ хуулийн 44.1-д заасан этгээд дуудлага худалдааг хүчингүй гэж зарлан, дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулахаас татгалзана:

46.2.1. нэг ч оролцогч бүртгүүлээгүй, эсхүл бүртгүүлсэн нэг ч оролцогч дуудлага худалдаанд оролцоогүй;

46.2.2. санал ирээгүй, эсхүл шаардлага хангасан нэг ч санал ирээгүй;

46.2.3. оролцогчид дуудлага худалдаа хөтлөгчийн зааварчилгааг дагаагүй, дуудлага худалдааны журам, дэг зөрчсөн;

46.2.4. дуудлага худалдааны үеэр оролцогчид өөр хоорондоо хуйвалдсан, түүнтэй төсөөтэй үйлдэл гаргасан бөгөөд энэ нь дуудлага худалдааны үр дүнд нөлөөлсөн болох нь илэрвэл;

46.2.5. доод үнэ тогтоогоогүй дуудлага худалдааны хожлын санал нь төр, эсхүл орон нутагт эдийн засгийн үр ашиггүй.

46.3.Энэ хуулийн 44.2-т зааснаас гадна дараахь тохиолдолд энэ хуулийн 44.1-д заасан этгээд дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулахаас татгалзана:

46.3.1.дуудлага худалдааг зохион байгуулах этгээд, эсхүл дуудлага худалдааны хөтлөгч нь дуудлага худалдаа явуулах журам, дэгийг зөрчсөн;

46.3.2.хуульд заасан дуудлага худалдааны журам зөрчигдсэн нь дуудлага худалдааны үр дүнд нөлөөлсөн;

46.3.3.дуудлага худалдаанд ялагч нь дуудлага худалдаанд оролцох эрхгүй этгээд бол.

46.4.Дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулахаас татгалзсан бол шалтгаан, үндэслэлийг бичгээр тодорхой дурдана.

46.5.Дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулсан шийдвэрт дуудлага худалдааны ялагчийн нэрийг, ялсан үнийн саналын хамт дурдана. Дуудлага худалдааны бэлэн мөнгөний дэнчинг доод үнийн 5-аас доошгүй хувиар тогтоосон бол шийдвэрт дуудлага худалдаанд хоёр дахь дээд үнийн санал ирүүлсэн этгээдийн нэрийг, үнийн саналын хамт тусгана.

47 дугаар зүйл.Гэрээ байгуулах

47.1.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах, шилжүүлэх шийдвэр гаргасан этгээд хөрөнгийг ашиглуулах, шилжүүлэх гэрээ байгуулах хугацааг дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулснаас хойш 2 сараас илүүгүй байхаар тогтооно. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацааг сунгаж болно.

47.2.Ялагч гэрээ байгуулахаас зайлсхийсэн гэж үзвэл төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах, шилжүүлэх шийдвэр гаргасан этгээд дуудлага худалдааг хүчингүй гэж зарлаж болно.

47.3.Дуудлага худалдааны ялагч энэ хуульд заасан хугацаанд гэрээ байгуулаагүй, эсхүл гэрээний үүргийг гүйцэтгэх баталгаа гаргаж чадаагүй бөгөөд дуудлага худалдааны доод үнийн 5-аас доошгүй хувьтай тэнцэх бэлэн мөнгөөр дэнчин тавьсан бол дуудлага худалдааны хоёр дахь дээд үнийн санал өгсөн этгээд гэрээ байгуулж болно. Энэ тохиолдолд нэг сар хүртэл хугацааны дотор гэрээг байгуулах ба энэ хугацааг дуудлага худалдаа зохион байгуулагч тогтооно.

48 дугаар зүйл.Уралдаант шалгаруулалтын аргыг хэрэглэх

48.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах, шилжүүлэх тусгай болзол шаардлагыг тогтоох бол уралдаант шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.

48.2.Төрийн болон орон нутгийн өмчийг уралдаант шалгаруулалтаар ашиглуулах, шилжүүлэх шийдвэр гаргасан этгээд оролцогчийн ирүүлсэн үнийн санал болон нэмэлт нөхцөлийг хэрхэн хангаж байгааг үндэслэн тогтоосон төсөл ирүүлсэн оролцогчтой гэрээ байгуулна.

48.3.Энэ хуулийн 75, 76 дугаар зүйл уралдаант шалгаруулалтын харилцаанд нэгэн адил үйлчилнэ.

49 дүгээр зүйл.Уралдаант шалгаруулалтын нэмэлт нөхцөл

49.1.Уралдаант шалгаруулалтаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах, бусдын удирдлага, өмчлөлд шилжүүлэхэд дараахь нэмэлт нөхцөл тогтоож болно:

49.1.1.хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх зэрэг байдлаар хөрөнгө оруулалт хийх;

49.1.2.хөрөнгийг тусгай зориулалтаар ашиглах үүрэг хүлээлгэх;

49.1.3.ажилтнуудыг тогтвортой ажиллуулах;

49.1.4.шинэ ажлын байр бий болгох;

49.1.5.тогтоосон шаардлагад нийцсэн техникийн, санхүүгийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах;

49.1.6.байгаль орчныг хамгаалах шаардлагыг биелүүлэх;

49.1.7.төрийн болон орон нутгийн өмчийг уралдаант шалгаруулалтаар ашиглуулах, шилжүүлэх шийдвэр гаргасан этгээдээс тогтоосон бусад нэмэлт нөхцөл.

49.2.Хөрөнгийг шилжүүлэн авсан, ашиглаж байгаа этгээд энэ хуульд заасан нэмэлт нөхцлийг хожим зөрчих нь уралдаанд шалгаруулалтын үндсэн дээр байгуулсан гэрээг цуцлах, гэрээнээс татгалзах үндэслэл болно.

50 дугаар зүйл.Хөрөнгийг өмчлөх эрх дуусгавар болох

50.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн өмчлөх эрх Иргэний хууль, энэ хуульд заасан үндэслэлээр дуусгавар болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГИЙГ ХУВЬЧЛАХ

51 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хувьчлах

51.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг Улсын Их Хурал, Засгийн газрын, орон нутгийн өмчийн хөрөнгийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр энэ хуульд заасан арга, хэлбэрээр хувьчилна. Хувьчлах шийдвэр нь хөрөнгө тус бүрээр гарах бөгөөд хувьчлах арга, хэлбэр, нөхцлийг шийдвэрт тусгана.

52 дугаар зүйл.Хувьчлах арга, түүнийг тодорхойлох

52.1.Төрийн өмчийн хөрөнгийг хувьчлахад дараахь аргыг дангаар буюу хослуулан хэрэглэнэ:

52.1.1.дуудлага худалдаагаар худалдах;

52.1.2.уралдаант шалгаруулалт /төсөл сонгон шалгаруулах/;

52.1.3.төрийн өмчийн хувьцааг худалдах;

52.1.4.менежментийн үр дүнг харгалзан хувьчлах;

52.1.5.давуу эрхийн хувьцаа, алтан хувьцаа гаргах.

53 дугаар зүйл.Хувьчлалд бэлтгэх

53.1.Төрийн өмчийг хувьчлахын өмнө хувьчлах хөрөнгөд тооллого хийж, Төрийн өмчийн хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтад шилжүүлнэ.

53.2.Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хувьчлах хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцан хамгаалах, Төрийн өмчийн хорооны шийдвэрийн дагуу уг хөрөнгийг шинэ өмчлөгчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.

53.3.Хувьчлах хөрөнгийг хяналтад авснаас шинэ өмчлөгчид хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр хөдөлгөөн хийхийг хориглоно.

53.4.Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагааны журмыг Төрийн өмчийн хороо батална.

53.5.Хүлээлгэн өгөхөд гарсан хөрөнгийн илүүдэл, дутагдлын асуудлыг Төрийн өмчийн хороонд тавьж шийдвэрлүүлнэ.

54 дүгээр зүйл.Төрийн өмчийг хувьчлах талаар мэдээлэх

54.1.Хувьчлагдах хөрөнгийн талаарх зар мэдээллийг 30-аас доошгүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон байгууллагын цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.

54.2.Хувьчлах тухай зар мэдээлэлд дараахь зүйлийг заавал тусгана:

54.2.1.хувьчлагдах хуулийн этгээдийн эзэмшилд байгаа газрын хэмжээ, зориулалт;

54.2.2.нийт хөрөнгийн дүн, өр, авлагыг бүрэн тусгасан тухайн жил, улирлын тайлан, тэнцэл, эдийн засгийн үр ашгийн болон төлбөрийн чадварыг илэрхийлэх үзүүлэлтүүд;

54.2.3.үйл ажиллагааны чиглэл;

54.2.4.хувьчлах хөрөнгийн худалдах доод үнэ;

54.2.5.эд хөрөнгө, ажил үйлчилгээний нөхцөл, онцлогтой холбогдох бусад мэдээлэл.

55 дугаар зүйл.Хувьчлах эд хөрөнгийг үнэлэх

55.1.Төрийн өмчийн хөрөнгийг хувьчлахаас өмнө худалдах доод үнийг тогтооно.

55.2.Хөрөнгийг худалдах доод үнээс бага үнээр худалдахыг хориглоно.

55.3.Хувьчлах хөрөнгийн худалдах доод үнийг Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасны дагуу хийсэн үнэлгээг харгалзан Төрийн өмчийн хороо тогтооно.

56 дугаар зүйл.Уралдаант шалгаруулалтаар өмч хувьчлах

56.1.Төрийн өмчийн хөрөнгийг дараахь нөхцөлд уралдаант шалгаруулалтаар хувьчилна:

56.1.1.үндсэн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүйгээр хөрөнгө оруулж, технологийг шинэчлэх замаар хуулийн этгээдийн үр ашгийг нь дээшлүүлэх;

56.1.2.хуулийн этгээдийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг нийгэм, бүс нутгийн болон хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлж өөрчлөн байгуулах.

57 дугаар зүйл.Уралдаант шалгаруулалтыг зарлах

57.1.Төрийн өмчийг уралдаант шалгаруулалтаар хувьчлах тухай зар мэдээллийг 60-аас доошгүй хоногийн өмнө мэдээлнэ.

57.2.Уралдаант шалгаруулалтаар хувьчлах тухай зар мэдээлэлд дараахь зүйлийг заавал тусгана:

57.2.1.хувьчлагдах хөрөнгийн цаашдын ашиглалт, захиран зарцуулалтад тавих нэмэлт болзол, шаардлага;

57.2.2.уралдаант шалгаруулалтын шалгуур үзүүлэлтүүд;

57.2.3.шалгаруулалтад оролцогчдыг урьдчилан бүртгэх хугацаа;

57.2.4.уралдаант шалгаруулалтын төслийг ирүүлэх эцсийн хугацаа;

57.2.5.гэрээний ерөнхий нөхцөл;

57.2.6.уралдаант шалгаруулалтад оролцогчдын төлөх дэнчин, хураамжийн хэмжээ.

58 дугаар зүйл.Төрийн өмчийн хувьцааг худалдах

58.1.Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн төрд ногдох хувьцааг эрх бүхий байгууллагын шийдвэрээр үнэт цаасны зохицуулалттай зах зээлд нээлттэй худалдана.

58.2.Хувьцааг үнэт цаасны зохицуулалттай зах зээлд худалдахдаа Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу зохион байгуулна.

58.3.Үндэсний аюулгүй байдал, стратегийн ач холбогдолтой төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн төрд ногдох хувьцааг худалдах талаар Засгийн газар тусгайлан журам тогтоож болно.

59 дүгээр зүйл.Үнэт цаас худалдах тусгай арга

59.1.төрийн болон орон нутгийн өмчийн үнэт цаасыг дараахь нэмэлт аргаар худалдаж болно:

59.1.1.үнэт цаасны зохицуулалттай зах зээл дэх нээлттэй арилжаагаар худалдах;

59.1.2.тодорхой төрлийн үнэт цаасыг үнэт цаасны тухай хууль тогтоомжид заасан тусгайлсан арга, хэрэгслээр худалдах;

59.1.3.хувьцааг солих, хөрвүүлэх, бусад төрлийн үнэт цаасыг өөр төрлийн үнэт цаасаар солих;

59.1.4.компанийн (хувьцааг) бусад хувьцаа эзэмшигчдэд санал болгох;

59.1.5.нээлттэй хувьцаат компанийн хувьцааг давуу эрхээр худалдах;

59.1.6.үнэт цаасыг гаргах шийдвэр болон хууль тогтоомжид заасан бусад нөхцөлөөр худалдах.

60 дугаар зүйл.Давуу эрхийн хувьцаа, алтан хувьцаа гаргах

60.1.Төрийн өмчийн компанийн хөрөнгийг хувьчлахдаа шаардлагатай бол давуу эрхийн хувьцаа эзэмшиж болно.

60.2.Засгийн газар төрийн өмчийн болон төрийн өмч давамгайлсан компанийн төрд ногдох хэсгийг бүхэлд нь хувьчлах тухай шийдвэр гаргахдаа зарим үйл ажиллагаанд төрөөс тодорхой хугацаанд хяналт тавьж зохицуулах зорилгоор алтан хувьцаа гаргахаар зааж болно.

60.3.Давуу эрхийн болон алтан хувьцаа гаргах асуудлыг Компанийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.

61 дүгээр зүйл. Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах

61.1. Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдах үйл ажиллагааг удирдлагын өндөр мэргэшил, дадлагатай, үйлдвэрлэлийг үр ашигтай зохион байгуулах ур чадвартай иргэн, хуулийн этгээдээр менежментийн гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

61.2. Менежментийн гэрээгээр ажиллах этгээд нь гэрээнд заасан бол өөрийн багийг бүрдүүлж болно.

61.3. Менежментийн гэрээг төсөл сонгон шалгаруулалтын үндсэн дээр хуульд өөрөөр заагаагүй бол тодорхой хугацаагаар бичгээр байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина.

61.4. Менежментийн гэрээнд үүргийн тухай болон ажил гүйцэтгэх гэрээний тухай Иргэний хуулийн зохицуулалтыг тусгахаас гадна дараахь болзлыг заавал тусгана:

61.4.1. менежментийн гэрээг хэрэгжүүлэгч этгээдээс үйлдвэрлэл, үйл ажиллагааны зохион байгуулалт, технологийн үйл ажиллагааг өөрчлөн байгуулах болон үр ашиг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, үе шат, дүгнэж үнэлэх шалгуур үзүүлэлт, журам;

61.4.2. менежментийн гэрээ хэрэгжүүлэгч этгээдийн цалин хөлс, урамшуулал;

61.4.3. гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлсэн нөхцөлд төрийн өмчийн эд хөрөнгөөс хувьчлан өгөх хэмжээ, хэлбэр, үнэ;

61.4.4. гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй нөхцөлд хүлээлгэх хариуцлага, учруулсан хохирлыг нөхөн төлөх хэлбэр, хэмжээ, түүнд барьцаалах хөрөнгө.

62 дугаар зүйл. Өмч хувьчлан авагч этгээдтэй байгуулах гэрээ

62.1. Хувьчилсан хөрөнгийг шилжүүлэхийн өмнө Төрийн өмчийн хороо шинэ өмчлөгчтэй худалдах худалдан авах гэрээ байгуулна.

62.2. Гэрээнд дараахь нөхцөлийг заавал тусгасан байна:

62.2.1. төрийн өмчийг хувьчилсан болон хувьчилж авсан этгээдийн нэр, хаяг;

62.2.2. хувьчилсан хөрөнгийн нийт үнэ, түүнийг төлөх хугацаа, хэлбэр;

62.2.3. өмчлөх эрхийн гэрчилгээ олгох нөхцөл;

62.2.4. хувьчилсан хөрөнгийг шинэ өмчлөгчид шилжүүлэн өгөх буюу хүлээн авах газар, хугацаа, журам, хүлээлцэх ажлыг гүйцэтгэх этгээд, тэдгээрийн эрх, үүрэг;

62.2.5. гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах арга;

62.2.6. хувьчлан авсан хөрөнгийн ашиглалтын талаар өмчлөгч төрийн өмнө үүрэг хүлээсэн бол уг үүрэг, хариуцлага, түүнчлэн эд хөрөнгийг хүлээн авах, хүлээлгэн өгөх хугацаа, журам зөрчсөний хариуцлага.

62.3. Гэрээнд хөрөнгө хүлээлгэн өгсөн тухай акт болон тодорхой төсөл хэрэгжүүлэх болзолтой бол холбогдох баримт бичгийг заавал хавсаргана.

63 дугаар зүйл. Хувьчлалыг хүчингүйд тооцох үндэслэл

63.1.Хувьчлалыг дараахь үндэслэлээр хууль бус гэж үзэж хүчингүй болгоно:
63.1.1.Эрх бүхий этгээдийн шийдвэр, зөвшөөрөлгүй хувьчилсан;
63.1.2.дуудлага худалдааны болон уралдаант шалгаруулалтын журам зөрчсөн;
63.1.3.хувьчлан авагч хөрөнгийн үнэ, хууль, гэрээнд заасан бусад төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй;
63.1.4.худалдах доод үнээс бага үнээр худалдсан буюу хувьчлахыг зөвшөөрөөгүй хөрөнгө оролцуулан авсан, өгсөн;
63.1.5.хувьчлан авагч хөрөнгө хувьчлан авсан тухай гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь зохих ёсоор биелүүлээгүй;
63.1.6.хувьчилсан хөрөнгийн үнийг төлөхөд хуулиар хориглосон эх үүсвэрийг ашигласан;

63.2.Энэ зүйлийн 63.1-д заасан үндэслэлээр хувьчлалыг хүчингүйд тооцох шийдвэрийг Төрийн өмчийн хороо гаргана.

63.3.Хувьчлал хүчингүй болсон тохиолдолд Төрийн өмчийн хороо хөрөнгийг хамгаалах болон цаашид авах арга хэмжээний талаар шийдвэр гаргана.

64 дүгээр зүйл.Хувьчлалын орлого

64.1.Хувьчлалыг зохион байгуулах зардлыг төсвөөс санхүүжүүлнэ.

64.2.Хувьчлалын орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ.

65 дугаар зүйл.Хувьчлалын тайлан

65.1.Төрийн өмчийн хөрөнгийг хувьчилсан тухай бүр хувьчлалын тайланг батлагдсан загварын дагуу бүрдүүлж, Төрийн өмчийн хороо батална.

65.2.Баталсан тайланг зохих журмын дагуу архивд шилжүүлнэ.

65.3.Төрийн өмчийн хороо нь төрийн өмчийн хөрөнгийг хувьчилсан тухай бүр холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

66 дугаар зүйл.Хувьчлалын дараахь хяналт

66.1.Хувьчлалд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор хувьчлалын дараахь хяналтыг Засгийн газрын шийдвэрээр хэрэгжүүлнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

67 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хяналтын тогтолцоо

67.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хяналт нь төрийн хяналт шалгалт, өмчлөгчийн хяналт, хуулийн этгээдийн дотоод хяналтаас тус тус бүрдэнэ.

67.2.Төрийн хяналт шалгалтыг төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

67.3.Төрийн өмчийн өмчлөгчийн хяналтыг Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн өмчлөгчийн хяналтыг иргэдийн Төлөөлөгчдийн хурал, түүний эрх олгосон этгээд хэрэгжүүлнэ.

67.4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад хяналт тавих улсын байцаагчийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр томилно.

67.5.Улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

68 дугаар зүйл.Өмчлөгчийн хяналт

68.1.Төрийн болон орон нутгийн өмчид өмчлөгчийн хяналтыг дараахь хэлбэрээр хэрэгжүүлнэ:

68.1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого тайлан гаргах ажлыг зохион байгуулж удирдах, улсын хэмжээний нэгдсэн дүн мэдээг гаргах;

68.1.2.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх;

68.1.3.төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөвлөлт, орлого, зардлын хуваарилалт;

68.1.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын үр дүн, хөрөнгийн удирдлагын талаар гаргасан шийдвэр, гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулсан, дүгнэсэн байдал;

68.1.5.дотоод хяналт шалгалт, аудитын тайлан ба зөрчил, дутагдлыг арилгах талаар авсан арга хэмжээний үр дүн;

68.1.6.хариуцлага тооцох.

69 дүгээр зүйл.Дотоодын хяналт шалгалт

69.1.Дотоодын хяналт, шалгалтыг төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд өөрөө хэрэгжүүлнэ.

69.2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий байнгын ажиллагаатай, орон тооны бус Өмч хамгаалах байнгын зөвлөл ажиллана.

69.3.Өмч хамгаалах байнгын зөвлөлийг үндсэн үйл ажиллагаа эрхэлсэн дэд дарга, захирал ахлаж, нягтлан бодогч, эд хариуцагч, мэргэжлийн /инженер, техникийн/ ажилтаны бүрэлдэхүүнтэй, захирлын шийдвэрээр байгуулна.

69.4.Төрийн захиргааны төв байгууллага, нутгийн удирдлагын байгууллага нь өөрийн салбар, харьяа байгууллага, хуулийн этгээдийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанд салбарын хэмжээний төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт, үнэлгээг зохион байгуулж, хийсэн хяналт шалгалтын тайланг жил бүрийн эхний улиралд багтаан Төрийн өмчийн хороонд хүргүүлнэ.

69.5.Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь өөрийн эзэмшил, өмчлөлд байгаа төрийн өмчийн хөрөнгийн талаар дотоодын хяналт шалгалтыг жил бүр заавал зохион байгуулах бөгөөд хяналт шалгалтын

тайланг баталгаажуулан тухайн жилийн 12 дугаар сарын 25-ны дотор төрийн өмчийн нэгдсэн мэдээллийн санд оруулна.

69.6.Төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд бүр өмч хамгаалах байнгын зөвлөлийг ажиллуулна. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журмыг Төрийн өмчийн хороо батална.

70 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого

70.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр дүнтэй ашиглах, хяналт тавих зорилгоор бүртгэл хөтөлнө.

70.2.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл нь төрийн болон орон нутгийн өмч, тэдгээрт хамаарах эдийн болон эдийн бус баялаг, хөрөнгийг өмчлөх эрх үүсэх, түүнтэй холбоотой бусад эрх, үүрэг, тэдгээрийн өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой бүртгэлийн үйл ажиллагааг хамруулна.

70.3.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл нь дараахь төрөлтэй байна:

- 70.3.1.төрийн нийтийн өмчийн бүртгэл;
- 70.3.2.төрийн тусгайлсан өмчийн бүртгэл;
- 70.3.3.орон нутгийн өмчийн бүртгэл.

71 дүгээр зүйл.Төрийн нийтийн өмчийн бүртгэл, тооллого

71.1.Төрийн нийтийн өмчийн бүртгэл, тооллогыг энэ хуульд нийцсэн тухайлсан хуулиар нарийвчлан зохицуулна.

71.2.Төрийн нийтийн өмчийн бүртгэлийг эрх бүхий төрийн захиргааны байгууллага хариуцан хөтөлж Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх, шинэчлэх ажлыг Төрийн өмчийн хорооны мэргэжил арга зүйн дагуу хийж гүйцэтгэнэ.

72 дугаар зүйл.Төрийн тусгайлсан өмчийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл

72.1.Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэл нь дараахь зүйлээс бүрдэнэ:

- 72.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, тэдгээрийн өмч, хөрөнгө;
- 72.1.2.төрийн өмчийн газар, түүний дотор төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд эзэмших, ашиглах эрх бүхий газар;
- 72.1.3.компани дахь төрийн эзэмшлийн хувь, хувьцаа;
- 72.1.4.төрийн өмчид хамаарах соёлын биет өв;
- 72.1.5.төрийн өмчид хамаарах оюуны өмч;
- 72.1.6.бусад өмч, хөрөнгө, эрх;
- 72.1.7.Итгэмжлэл, бусад удирдлагын гэрээгээр шилжүүлсэн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө.

72.2.Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийн бүртгэлийг Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай

хуульд нийцүүлэн улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг Улсын бүртгэл байгууллагатай хамтран зохион байгуулна.

72.3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл нь тухайн хөрөнгийн төлөв байдлыг илэрхийлэх буюу бусад хөрөнгөөс ялгагдах онцлог байдлыг тусгасан мэдээллийг агуулах бөгөөд бүртгэлийн нэгдсэн ангилал, код, маягт, аргачлалыг Үндэсний статистикийн хорооны зөвшөөрлөөр Төрийн өмчийн хороо батална.

72.4.Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна оршиж буй Монгол Улсын төрийн өмчийн бүртгэлийг Гадаад харилцааны яам хариуцан хөтөлж, төрийн өмчийн бүртгэл мэдээллийн санд бүртгүүлэх, шинэчлэх ажлыг Төрийн өмчийн хорооны мэргэжил арга зүйн дагуу хийж гүйцэтгэнэ.

72.5.Монгол Улсын улсын нөөцийн бараа, материал, материаллаг зүйлийн бүртгэлийг эрх бүхий байгууллага хөтөлж, удирдана.

72.6.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл нь дараахь мэдээллийг агуулсан байна:

72.6.1.Хөрөнгийн бусад хөрөнгөөс ялгаж тодорхойлох мэдээлэл;

72.6.2.Тухайн хөрөнгийн (удирдлага) хадгалалт хамгаалалтыг хариуцах эрх бүхий этгээдийн мэдээлэл;

72.6.3.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн өмчлөх, эзэмших, ашиглах, түүнтэй холбоотой бусад эрх үүссэн, нэмэгдсэн, өөрчлөгдсөн, дуусгавар болсонтой холбогдох мэдээ, мэдээлэл;

72.6.4.төр хяналтын багцыг эзэмшиж буй төрийн өмчийн компанийн хөгжлийн богино, дунд, урт хугацааны бизнес, стратеги төлөвлөлт.

72.7.Төрийн нийтийн болон тусгайлсан өмч, хөрөнгийн бүртгэлийг Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэлийг Өмчийн газар хариуцан зохион байгуулж, нэгдсэн бүртгэлийг төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд нэгтгэн, хөрөнгө бүрт бүртгэлийн дугаарыг олгож, өмчлөх эрхийг баталгаажуулна.

72.8.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл хөтлөх, мэдээллийн сангийн журмыг Засгийн газар батална.

73 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан

73.1.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан гэж нэгдсэн ангилал, код, индекс, арга зүй, стандарт, баримт бичгийн шаардлага болон хуульд заасны дагуу цуглуулж, боловсруулж, хадгалсан төрийн болон орон нутгийн өмч бүхий хуулийн этгээд, эд хөрөнгийн цаасан болон цахим мэдээллийн бүрдлийг хэлнэ. Уг сан нь төрийн өмч байна.

73.2.Бүртгэл мэдээллийн нэгдсэн санд гэж эх нотлох баримт бичгийг зурган болон дижитал хэлбэрээр хадгалсан хувийг цахим архивын сан үүсгэн хадгална.

73.3.Бүртгэл мэдээллийн нэгдсэн сан нь энэ хуулийн 70.3-д заасан мэдээлэл, эх нотлох баримт бичгийн архив, цахим мэдээллийн сангаас бүрдэнэ.

73.4.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь Засгийн газрын нэгдсэн мэдээллийн санд холбогдоно.

73.5.Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь улсын төрөлжсөн бүртгэлд хамаарах бөгөөд сангийн өгөгдөл, мэдээлэл бичмэл болон цахим хэлбэртэй байна.

73.6.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын цаасан суурьтай мэдээлэл, өгөгдөл, цахим мэдээлэл нь мэдээллийн нэгдсэн сангийн эх сурвалж болно.

73.7.Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь 73.3-д зааснаас гадна дараахь төрлийн мэдээллээс бүрдэнэ:

73.7.1.төрийн нийтийн ба тусгайлсан өмч, орон нутгийн өмч,хөрөнгийн төлөв байдал, тэдгээрийн хөдөлгөөн /олж авах, шилжүүлэх, данснаас хасах/;

73.7.2.төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, хуулийн этгээдийн мэдээлэл /хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбох/;

73.7.3.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэх гэрээний бүртгэл /эд хөрөнгө, эрхийн улсын бүртгэлтэй холбох/;

73.7.4.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, үйл ажиллагааны үр дүн, тайлагнал;

73.7.5.хяналт шалгалт, үнэлгээний тайлан.

73.8.Бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл оруулах, өөрчлөх, боловсруулах, баталгаажуулах, хадгалах ажлыг Төрийн өмчийн хороо болон Өмчийн газар хариуцан зохион байгуулж, сангийн үйл ажиллагааны журмыг баталж мөрдүүлнэ.

73.9.Төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, хуулийн этгээд мэдээллийг бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд энэ хуульд заасан мэдээллийг бүрэн оруулах үүрэг хүлээнэ.

73.10.Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, цахим сүлжээ үрэгдэх, устгагдахаас бүрэн хамгаалагдсан байх бөгөөд улсын онцгой объектын зэрэглэлтэй байна.

73.11.Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн нууцлал, эх нотлох баримт бичгийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах үүргийг Төрийн өмчийн хороо болон Өмчийн газар хүлээнэ.

73.12.Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь төрийн мэдээллийн бусад сантай мэдээлэл солилцох боломжтой байх бөгөөд төрийн мэдээллийн сан хариуцсан байгууллагад дундын мэдээллийн сан үүсгэн ажиллуулна.

73.13.Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагааны зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгана.

73.14.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан гаргах ажлыг зохион байгуулж удирдах, улсын хэмжээний нэгдсэн дүн мэдээг гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх, боловсруулах, баяжуулах, хадгалах замаар төрийн өмчид бүртгэлээр хяналт тавина.

73.15.Бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд байгаа төрийн болон албаны нууцын тухай хуулиар нууцад хамаарахаас бусад мэдээлэл нь ил тод, нээлттэй байна.

73.16.Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг цахим хэлбэрээр бүрдүүлэх, хөгжүүлэх боломжтой байна.

73.17.Бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийн хуулбар сан нь төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагад хадгалагдана.

73.18.Бүртгэлийн цахим мэдээллийн сангийн систем, техник технологи, программ хангамжийн ерөнхий шаардлага болон төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагатай мэдээлэл солилцох журмыг Засгийн газар батална.

73.19.Төрийн нууцад хамаарах мэдээллийг бүртгэл, мэдээллийн санд оруулахгүй.

74 дүгээр зүйл.Төрийн тусгайлсан өмчийн хөрөнгийн тооллого

74.1.Төрийнтусгайлсан өмчийн хөрөнгийн тооллогыг улсын тооллого, дотоодын тооллого ба зорилтот тооллого гэж гурав ангилна. Улсын тооллогыг явуулах аргачлал, арга зүй, санхүүжилт, тайлагналын журмыг Засгийн газрын тогтоолоор батална.

74.2.Төрийн тусгайлсан өмчийн болон орон нутгийн өмчийн эргэлтийн бус хөрөнгийн, шаардлагатай гэж үзвэл эргэлтийн хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг Төрийн өмчийн хороо эрхлэн 4 жилд нэг удаа зохион байгуулна.

74.3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн байгууллага болон төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага дараахь хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана:

74.3.1.үндсэн,хөрөнгө,дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа, 12 дугаар сарын 01-ний өдрөөс 31-ний өдрийн дотор;

74.3.2.түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа, 6 дугаар сарын 01-ний өдөр, 12 дугаар сарын 01-ний өдрөөс;

74.3.3.дуусаагүй үйлдвэрлэл, өөрийн үйлдвэрийн хагас боловсруулсан зүйл, үнэт цаасны тооллогыг улиралд 1 удаа, улирлын сүүлийн сарын 25-ны өдрөөс;

74.3.4.мөнгөн хөрөнгө, шатах, тослох материал, бараа, сав, боодлыг сар бүрийн 01-ний өдрөөр;

74.3.5. мал, амьтдыг жилд 1 удаа, 12 дугаар сарын 15-ны өдрөөр;

74.3.6.банкны байгууллагаас бүх төрлийн харилцах дансны хуулгыг авах бүрт дансны гүйлгээг шалгаж, улирал бүрийн дансны үлдэгдлийг баталгаажуулах.

74.4.Төрийн байгууллага болон төрийн өмчит хуулийн этгээд нь хөрөнгийн дотоодын тооллогоор дутагдсан, илүүдсэн хөрөнгө болон цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийн талаарх мэдээллийг холбогдох баримтын хамт эрх бүхий байгууллагад хүргүүлж, зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

74.5.Шаардлагатай тохиолдолд Засгийн газрын шийдвэрийн дагуу зорилтот тооллого явуулж болно.

74.6.Улсын үзлэг, тооллого, зорилтот тооллогын зардлыг улсын төсөвт тусгана.

75 дугаар зүйл.Хөрөнгийн тооллогын бэлтгэлийг хангах

75.1.Төрийн байгууллага болон төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, Өмч хамгаалах байнгын зөвлөл, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараахь бэлтгэлийг хангасан байх үүрэгтэй:

75.1.1.үндсэн хөрөнгө, түүнд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодох дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх;

75.1.2.бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хөрөнгө хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх;

75.1.3.агуулахад байгаа түүхий эд, материал, бэлэн бүтээгдэхүүн, сэлбэг хэрэгсэл зэрэг эд хөрөнгийг төрөлжүүлж, хураалт, хадгалалтыг цэгцэлсэн байх;

75.1.4.үйлдвэрлэлийн салбар, нэгжид байгаа хэрэгцээнээс илүү үндсэн хөрөнгө, түүхий,эд,хагас боловсруулсан зүйл,бэлэн бүтээгдэхүүн ашиглаж болох хоёрдогч түүхий эд зэргийг агуулахад шилжүүлж гологдол болсон бүтээгдэхүүнийг шийдвэрлэсэн, гүйцэтгэсэн ажлын бүртгэл хөтлүүлж, дуусаагүй ажлын хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажлын хэмжээг тодорхойлсон байх;

75.1.5.мал, амьтныг эзэмшигч бүрээр тоолоход бэлтгүүлэх;

75.1.6.тооллогод хэрэглэгдэх хэмжих багаж, хэрэгслийг шалган баталгаажуулж бараа материалын үнийн болон хэвийн хорогдлын нормын жагсаалтыг үйлдсэн байх;

75.1.7.өмнөх тооллогоор тайлан тэнцлээс хасахаар шийдвэрлэсэн үндсэн хөрөнгө, түүхий эд материал, бэлэн бүтээгдэхүүн, барааг худалдах, устгах зэргээр бүрэн шийдвэрлүүлж үр дүнг бүртгэлд тусгасан байх;

75.1.8.өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх;

75.1.9.Төрийн өмчийн хорооноос баталсан хөрөнгийн мэдээллийн маягтуудыг аргачлалын дагуу бүртгэж, бэлтгэсэн байх.

76 дугаар зүйл.Тооллогын комисс, түүний эрх, үүрэг

76.1.Төрийн байгууллага болон төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжилтнийг оролцуулан комисс байгуулна.

76.2.Комисс байгуулах шийдвэрт тооллого эхлэх, дуусгах хугацааг тооллого явуулах салбар, нэгж бүрээр заасан байна.

76.3.Улсын тооллогын үед зохион байгуулах, комиссын ажилд хяналт тавих, туслах төлөөлөгчийг Төрийн өмчийн хороо томилж ажиллуулна.

76.4.Тооллогын комисс дараахь эрхтэй:

76.4.1.тооллого эхлэхийн өмнө эд хариуцагчаас хөрөнгийн орлого, зарлагын бүх баримтыг нягтлан бодогчид бүрэн шилжүүлсэн эсэхээр баталгаа гаргуулан авах ба нягтлан бодогч уг баримтыг хүлээн авсан эсэхийг шалгах;

76.4.2.тооллого явуулахын өмнө хариуцагчийн хариуцаж байгаа бараа материалын үнэ бүхий зүйл, мөнгөн касс, агуулахыг лацдаж ломбодох болон харуул

хамгаалалтын талаар илэрсэн дутагдлыг арилгах арга хэмжээ авахыг холбогдох хүмүүст шаардах;

76.4.3.тооллогын явц дундуур түүхий эд, бараа материал, мөнгөн хөрөнгийг хүлээн авах, тавьж олгох явдлыг бүрэн зогсоох, байгууллагын хэвийн ажиллагааг тасалдуулахгүйн тулд тооллогын комиссын хяналт дор зөвхөн үйлдвэрлэлийн хэрэгцээний зайлшгүй шаардлагатай түүхий эд, материалыг гаргах ба хүлээн авахыг зөвшөөрөх.

76.5.Тооллогын комисс дараахь үүрэгтэй:

76.5.1.хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;

76.5.2.тоолсон, хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн жишиг үнэтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих;

76.5.3.агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, өмнөх тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах;

76.5.4.комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;

76.5.5.эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнээс өндөр үнээр авсан, доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих.

77 дугаар зүйл.Хөрөнгийн тооллогын үр дүнгээр авах арга хэмжээ

77.1.Хөрөнгийг санаатай ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл төрийн байгууллага болон төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага уг хэргийг ажлын 7 өдрийн дотор хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.

77.2.Байгууллага, хуулийн этгээдийн ерөнхий /ахлах/ нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш ажлын 5 өдрийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж, дансны үлдэгдлийг тулган шалгана.

78 дугаар зүйл.Орон нутгийн өмчийн хөрөнгийн тооллого

78.1.Орон нутгийн өмчийн хөрөнгийн тооллогыг тухайн орон нутгийн өмчийн удирдлагын асуудал эрхэлсэн байгууллага энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу зохион байгуулна.

79 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн үнэлгээ

79.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн үнэлгээг дараахь тохиолдолд заавал хийлгэнэ:

79.1.1.хөрөнгийг бусдад худалдаж шилжүүлэх;

79.1.2.өмч хувьчлал явуулах;

79.1.3.компани, санд хувь нийлүүлэх, хөрөнгө оруулах;

79.1.4.бусад этгээдээс хөрөнгө оруулах;

79.1.5.төрийн өмчийн компанийн хувьцааг нийтэд санал болгох;
79.1.6.хохирол арилгуулах, нэхэмжлэх;
79.1.7.авлагад тооцож хөрөнгө хүлээн авах, өглөгөд тооцож хөрөнгө шилжүүлэх;
79.1.8.барьцаа, үүргийн гүйцэтгэлийн баталгаанд тавих
79.1.9.хуульд заасан бусад.

79.2.Төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, хуулийн этгээд дараахь тохиолдолд хөрөнгийн үнэлгээг хийлгэж болно:

79.2.1.тухайн хөрөнгийн бүртгэлийн үнэ зах зээлийн үнээс материаллаг хэмжээний зөрүүтэй болсон;

79.2.2.ашиглалтын хугацаа дуусаж үлдэгдэл өртөггүй болсон боловч цаашид ашиглах боломжтой үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоох;

79.2.3.ашиглалтын хугацаа дуусаагүй боловч цаашид ажлын хэрэгцээ шаардлага хангахгүй эсхүл ашиглах боломжгүй хөдлөх хөрөнгө;

79.2.4.шаардлагатай бусад.

79.3.Энэ хуулийн 79.1-д заасан хөрөнгийн үнэлгээг эрх бүхий этгээдээр хийлгэнэ.

79.4.Үл хөдлөх хөрөнгө, түүх соёлын дурсгалт зүйлс, биет бус хөрөнгө, хязгаарлагдмал эрхээс бусад дараахь хөрөнгийн үнийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн саналыг үндэслэн тухайн төрийн өмчит байгууллага, хуулийн этгээд шинэчлэн тогтоож болно:

79.4.1.ашиглалтын хугацаа дуусаж үлдэгдэл өртөггүй болсон боловч цаашид ашиглах боломжтой хөдлөх хөрөнгө;

79.4.2.акталсан боловч бусдад худалдах боломжтой хөрөнгө.

80 дугаар зүйл.Тайлагнал

80.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд энэ хуульд заасан холбогдох мэдээ, тайланг Төрийн өмчийн хорооны баталсан маягт, зааврын дагуу тухай бүр, хөрөнгийн удирдлагын жилийн тайланг дараа жилийн эхний улиралд тайлагнах үүрэгтэй.

80.2.Төрийн өмчийн хороо, Өмчийн газар төрийн өмчийн төлөв байдал, нөөц, хөдөлгөөн, хөрөнгийн удирдлага, төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашгийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан тайланг жил бүр гаргаж Засгийн газарт хүргүүлнэ.

80.3.Хуулиар хориглоогүй бол төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний удирдлагад байгаа хөрөнгийн тухай мэдээлэл, хөрөнгийн удирдлагын тайлан олон нийтэд нээлттэй, ил тод байна.

АРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

81 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

81.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэм хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

81.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

82 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

82.1.Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.